



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** АРА-2022/49/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Архангай аймаг  
Булган сум  
2022 он

Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Д.Түмэнжаргал

Утас: 70005329 Цахим хаяг: [mbr.audit.llc@gmail.com](mailto:mbr.audit.llc@gmail.com)

Аудитын менежер: Н.Алтанзул

Утас: 70005329 Цахим хаяг: [mbr.audit.llc@gmail.com](mailto:mbr.audit.llc@gmail.com)

Аудитор: А.Жамъян

Утас: 70005329 Цахим хаяг: [mbr.audit.llc@gmail.com](mailto:mbr.audit.llc@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
<b>2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....</b>	<b>4</b>
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

АРХАНГАЙ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Д.АВАРЗЭД ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Булган Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>58,887,426.61</u></b>	<b><u>56,058,151.61</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b><u>58,887,426.61</u></b>	<b><u>56,058,151.61</u></b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b><u>51,267,426.61</u></b>	<b><u>40,818,151.61</u></b>
3542	Аж ахуйн материал	46,037,426.61	40,818,151.61
3544	Түлш, шатах тослох материал	5,230,000.00	-
35600	Мал амьтад	7,610,000.00	15,240,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,867,943,731.82</u></b>	<b><u>2,162,117,469.15</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b><u>1,867,943,731.82</u></b>	<b><u>2,162,117,469.15</u></b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b><u>1,814,721,731.74</u></b>	<b><u>2,108,945,469.05</u></b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,733,988,260.00	1,733,988,260.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(58,712,190.96)	(88,068,286.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	118,410,104.56	102,997,444.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(90,006,537.84)	(41,236,407.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	131,723,030.80	96,728,123.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(107,931,522.15)	(72,316,129.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	107,928,625.00	402,726,554.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(39,901,849.07)	(46,322,342.31)
39217	Ном	19,223,811.40	20,448,253.27
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b><u>53,222,000.08</u></b>	<b><u>53,172,000.10</u></b>
39301	Программ хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(199,999.92)	(249,999.90)
39303	Бусад биет бус хөрөнгө	53,122,000.00	53,122,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,926,821,158.43</u></b>	<b><u>2,218,175,620.76</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,926,821,158.43</u></b>	<b><u>2,218,175,620.76</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>1,926,821,158.43</u></b>	<b><u>2,218,175,620.76</u></b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	502,448,934.60	502,448,934.60
51101	Өмч: - төрийн		
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b><u>1,059,038,129.33</u></b>	<b><u>1,313,997,791.90</u></b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,059,038,129.33	1,059,038,129.33
51220	Тайлант үеийн үр дүн	-	254,959,662.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	365,334,094.50	401,728,894.26
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,926,821,158.43</u></b>	<b><u>2,218,175,620.76</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,061,186,367.61</b>	<b>963,500,582.78</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>26,943,767.61</b>	<b>333,780,051.87</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>26,943,767.61</b>	<b>333,780,051.87</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,943,767.61	9,120,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,849,720.00	9,120,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,094,047.61	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө	-	304,159,485.87
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	-	20,500,566.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,034,242,600.00</b>	<b>629,720,530.91</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	961,873,700.00	589,735,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	961,873,700.00	589,735,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	37,100.00	5,690,730.91
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,690,730.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,100.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	72,331,800.00	34,294,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,331,800.00	34,294,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>979,164,607.22</b>	<b>708,540,920.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>979,164,607.22</b>	<b>708,540,920.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	923,337,812.34	651,249,406.31
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	630,715,569.12	420,959,520.54
210101	Үндсэн цалин	495,114,679.50	289,866,975.54
210102	Нэмэгдэл	95,005,473.45	91,349,645.00
210104	Урамшуулал	40,595,416.17	39,742,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	91,827,103.00	69,549,254.56
210201	Тэтгэврийн даатгал	69,553,503.00	52,439,234.75
210202	Тэтгэмжийн даатгал	8,075,800.00	4,347,722.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,460,600.00	3,071,191.85
210204	Ажилгүйдлийн даатгал	1,615,000.00	1,102,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,122,200.00	8,588,605.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	78,554,687.00	48,523,396.00
210301	Гэрэл, цахилгаан	11,271,229.00	5,072,000.00
210302	Түлш, халаалт	66,747,458.00	42,199,396.00
210303	Цэвэр, бохир ус	536,000.00	1,252,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,345,391.00	23,013,309.91
210401	Бичиг хэрэг	1,099,150.00	299,628.91
210402	Тээвэр, шатахуун	4,094,141.00	3,181,770.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,018,200.00	314,286.00
210404	Ном, хэвлэл	-	885,286.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	218,900.00	139,004.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,915,000.00	2,047,160.00
210408	Бараа материал акалсны зардал	-	16,124,275.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>29,902,034.00</b>	<b>26,191,677.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,263,900.00	7,639,700.00
210502	Хоол, хүнс	22,518,134.00	16,622,477.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,120,000.00	1,929,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,000,500.00</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	3,000,500.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>182,500.00</b>	<b>148,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	182,500.00	148,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,598,403.00</b>	<b>5,758,640.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,698,403.00	5,758,640.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	900,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>78,211,652.22</b>	<b>57,253,608.30</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,317,900.00	729,648.34
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	74,893,725.22	56,523,959.96
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55,826,794.88</b>	<b>57,291,513.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,062,020.00</b>	<b>12,590,906.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,262,020.00	12,040,906.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	550,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>46,764,774.88</b>	<b>44,700,607.90</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	44,700,607.90
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>82,021,760.39</u></b>	<b><u>254,959,662.57</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b><u>1,970,000.00</u></b>	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,970,000.00	
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b><u>(1,970,000.00)</u></b>	
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>80,051,760.39</u></b>	<b><u>254,959,662.57</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,048,092,320.00</u></b>	<b><u>638,840,530.91</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,849,720.00</b>	<b>9,120,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>13,849,720.00</b>	<b>9,120,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>13,849,720.00</b>	<b>9,120,000.00</b>
<b>1200042</b>	<b>Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих</b>	<b>13,849,720.00</b>	<b>9,120,000.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,034,242,600.00</b>	<b>629,720,530.91</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	961,873,700.00	589,735,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	961,873,700.00	589,735,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	37,100.00	5,690,730.91
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,690,730.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,100.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	72,331,800.00	34,294,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,331,800.00	34,294,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>926,177,618.00</u></b>	<b><u>628,547,230.91</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>926,177,618.00</b>	<b>628,547,230.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>869,125,563.12</b>	<b>570,679,717.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	627,865,472.12	428,752,612.37
210101	Үндсэн цалин	492,140,805.50	295,995,912.37
210102	Нэмэгдэл	91,355,376.45	93,013,800.00
210104	Урамшуулал	44,369,290.17	39,742,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	104,706,400.00	61,756,162.73
210201	Тэтгэврийн даатгал	72,403,600.00	43,613,857.21
210202	Тэтгэмжийн даатгал	8,075,800.00	5,300,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,460,600.00	3,151,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,615,000.00	1,116,406.21
210205	Эрүүл мэндийн даатгал	16,151,400.00	8,574,699.31
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	76,784,687.00	42,294,000.00
210301	Гэрэл, цахилгаан	15,671,229.00	5,072,000.00
210302	Түлш, халаалт	60,577,458.00	34,862,000.00
210303	Цэвэр, бохир ус	536,000.00	2,360,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,811,991.00	6,797,030.91
210401	Бичиг хэрэг	893,800.00	290,630.91
210402	Тээвэр, шатахуун	4,094,141.00	3,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,143,400.00	413,700.00
210404	Ном, хэвлэл	-	885,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	218,900.00	138,400.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,461,750.00	2,069,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>32,389,310.00</b>	<b>25,160,111.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,263,900.00	8,149,700.00
210502	Хоол, хүнс	25,005,410.00	15,080,911.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,120,000.00	1,929,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,000,500.00</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	3,000,500.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>182,500.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	182,500.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,894,403.00</b>	<b>5,248,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,994,403.00	5,248,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	900,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,490,300.00</b>	<b>671,100.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,490,300.00	671,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>57,052,054.88</b>	<b>57,867,513.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,287,280.00</b>	<b>13,166,906.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,487,280.00	12,616,906.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	550,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>46,764,774.88</b>	<b>44,700,607.90</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,764,774.88	44,700,607.90
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>121,914,702.00</u></b>	<b><u>10,293,300.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>15,449,700.00</b>	<b>10,293,300.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,449,700.00</b>	<b>10,293,300.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>15,449,700.00</b>	<b>10,293,300.00</b>
223001	Бусад хөрөнгө	15,449,700.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		10,293,300.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(15,449,700.00)</u></b>	<b><u>(10,293,300.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>106,465,002.00</b>	<b>-</b>
<b>31</b>	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>31</b>	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>502,448,934.60</b>	<b>365,334,094.50</b>	<b>1,075,299,904.30</b>	<b>1,943,082,933.40</b>
20 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	502,448,934.60	365,334,094.50	1,059,038,129.33	1,926,821,158.43
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		36,394,799.76		36,394,799.76
Тайлант үеийн үр дүн			254,959,662.57	254,959,662.57
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>502,448,934.60</b>	<b>401,728,894.26</b>	<b>1,313,997,791.90</b>	<b>2,218,175,620.76</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	632,289,800.00	588,449,192.10	43,840,607.90	93.07%
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	632,289,800.00	588,449,192.10	43,840,607.90	93.07%
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	616,663,000.00	575,282,286.10	41,380,713.90	93.29%
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	463,857,300.00	428,752,612.37	35,104,687.63	92.43%
210101	Үндсэн цалин	331,100,600.00	295,995,912.37	53,618,396.00	89.10%
210102	Нэмэгдэл	93,013,800.00	93,013,800.00		100.00%
210104	Урамшуулал	39,742,900.00	39,742,900.00		100.00%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	62,752,300.00	61,756,162.73	996,137.27	98.41%
210201	Тэтгэврийн даатгал	45,308,900.00	43,613,857.21	1,695,042.79	96.26%
210202	Тэтгэмжийн даатгал	4,360,900.00	5,300,000.00	(939,100.00)	121.53%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,488,700.00	3,151,200.00	337,500.00	90.33%
210204	Ажилгүйдлийн даатгал	872,100.00	1,116,406.21	(244,306.21)	128.01%
210205	Эрүүл мэндийн даатгал	8,721,700.00	8,574,699.31	147,000.69	98.31%
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,294,000.00	42,294,000.00	-	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	5,072,000.00	5,072,000.00	-	100.0%
210302	Түлш, халаалт	34,862,000.00	34,862,000.00	-	100.0%
210303	Цэвэр, бохир ус	2,360,000.00	2,360,000.00	-	100.0%

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,934,300.00	5,934,300.00	-	100.0%
210401	Бичиг хэрэг	178,300.00	178,300.00	-	100.0%
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	3,000,000.00	-	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	413,700.00	413,700.00	-	100.0%
210404	Ном, хэвлэл	134,900.00	134,900.00	-	100.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	138,400.00	138,400.00	-	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,069,000.00	2,069,000.00	-	100.0%
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	29,402,000.00	24,122,111.00	5,279,889.00	82.04%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,111,700.00	7,111,700.00	-	100.0%
210502	Хоол, хүнс	20,360,800.00	15,080,911.00	5,279,889.00	74.07%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,929,500.00	1,929,500.00	-	100.0%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,883,000.00	10,883,000.00	-	100.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,883,000.00	10,883,000.00	-	100.0%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,540,100.00	1,540,100.00	-	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,540,100.00	1,540,100.00	-	100.0%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	15,626,800.00	13,166,906.00	2,459,894.00	84.26%
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	15,626,800.00	13,166,906.00	2,459,894.00	94.35%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,076,800.00	12,616,906.00	2,459,894.00	83.68%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	550,000.00	550,000.00	-	100.0%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	632,289,800.00	588,449,192.10	43,840,607.90	93.07%
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	589,735,800.00	545,035,192.10	44,700,607.90	92.42%
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	589,735,800.00	545,035,192.10	44,700,607.90	92.42%
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	34,294,000.00	34,294,000.00	-	100.0%
132001	Орон нутгийн төсвөөс	34,294,000.00	34,294,000.00	-	100.0%
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	8,260,000.00	9,120,000.00	(860,000.00)	110.41%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,260,000.00	9,120,000.00	(860,000.00)	110.41%
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>				
610001	Төсвийн байгууллага				
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>				
620001	Удирдах ажилтан				
620002	Гүйцэтгэх ажилтан				

620003	Үйлчлэх ажилтан				
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>				
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>				
630001	Төрийн өмчит ЕБС				
024	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				
028	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)				
033	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)				

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,690,730.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,690,730.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,690,730.91</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>862,730.91</b>
210401	Бичиг хэрэг	112,330.91
210404	Ном хэвлэл	750,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,038,000.00</b>
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,038,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,790,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,790,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,690,730.91</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>5,690,730.91</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,690,730.91

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй, дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Солонготуяа, аудитор А.Жамъян нар гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер Н.Алтанзул, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Хүүхэд бүрт сурах арга барил, зөв дадал хэвшил эзэмшүүлэх, багшийн хөгжлийг дэмжих сургууль" гэж тодорхойлжээ.

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Сургуулийн гадаад, дотоод орчин нөхцөлийг сайжруулж сурах орчинг бүрдүүлэх;
- Ажлын хариуцлага ёс зүйг дээшлүүлж хууль дүрмийг хэрэгжүүлэх;
- Ажлын хариуцлага ёс зүй хууль дүрмийг хэрэгжүүлэх;
- Суралцагч болон ажилчдын ажиллах нөхцлийг бүрдүүлэн хөлбөмбөгийн талбай, машины зогсоол, сургууль тойрсон төмөр хайс, гүйлтийн зам, саравч, сургуулийн гаднах өнгө үзэмжийг сайжруулах;
- Сургалтыг дэмжих үйл ажиллагаа;
- Сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- "ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль.
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны "Төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх тухай" А/190 дугаар тушаалаар батлагдсан Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө /2021-2023/
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2019 оны А\491 дугаар тушаал.
- Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны хамтарсан "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" А/35, А10/1 дугаар тушаалаар батлагдсан Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт.
- УИХ-ын чуулганы 06 сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Боловсролын тухай ерөнхий хуулийн төслийг баталсан.

- 2021.08.19-ны өдрийн Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А\292, А\525 тушаал,
- Монгол улсын боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/171 тушаал "Давтлага зохион байгуулах заавар батлах тухай" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага дотоод хяналтын журам, заавар боловсруулж, баталгаажуулаагүй байна.

Дотоод хяналтын комисс нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, хяналт хийж, тайланг захирлын зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна. Харин дотоод хяналтыг зөвхөн сургалтын үйл ажиллагаа, анги танхимын эрүүл ахуй, хүүхдийн эрүүл мэнд, хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлагын хүрээнд хийж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 668.8 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 13.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Булган сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 291.3 сая төгрөгөөр буюу 15.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	58.8	56.0	(2.8)
Биет хөрөнгө	1,814.7	2,108.9	294.2
Биет бус хөрөнгө	53.2	53.1	(0.05)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,926.8</b>	<b>2,218.1</b>	<b>291.3</b>
Хуримтлагдсан үр дүн	1,059.0	1,313.9	254.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,926.8</b>	<b>2,218.1</b>	<b>291.3</b>

3.5.1. Бараа материалын дансны үлдэгдэл 56.0 сая төгрөг болж 2.8 сая төгрөгөөр буурсан байна. Хангамжийн материал 10.4 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүссэн асуудал байхгүй байна.

3.5.2. Биет хөрөнгө дансны үлдэгдэл 294.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 294.7 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Архангай аймгийн орон нутгийн өмчийн газрын 2021 оны 101 дугаар шийдвэрээр элэгдлээрээ өртгөө нөхсөн 68.8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж тайлагнасан байна.

Биет бус хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 0.05 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлын 0.05 сая төгрөгийн бууралтаас шалтгаалжээ.

3.5.3. Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 1,313.9 сая төгрөг болж 254.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны 254.9 сая төгрөгийн ашигтай ажиллагаанаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 270.6 сая төгрөгөөр буюу 27.64 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс шимтгэлийн зардал болон байр ашиглалттай холбоотой зардал байна.

*Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/сая.төг/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,034.2	624.0	(410.1)
Үндсэн үйл ажиллагааны орлого	26.9	333.7	306.8
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.03	5.6	5.6
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	304.1	304.1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	20.5	20.5
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>1,061.1</b>	<b>963.5</b>	<b>(97.6)</b>
Цалин, шимтгэлийн зардал	722.5	490.5	(232.0)
Бусад бараа үйлчилгээний зардал	119.9	195.4	75.4
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2.5	5.7	3.1
Бараа үйлчилгээний бусад зардал	78.2	57.2	(20.9)
Урсгал шилжүүлэг	55.8	57.2	1.4
Хөрөнгө шилжүүлсэн	46.7	-	(46.7)
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>979.1</b>	<b>708.5</b>	<b>(270.6)</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>80.0</b>	<b>254.9</b>	174.9

Тус газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 410.1 сая төгрөг буюу 39.6 хувиар буурсан нь цар тахалтай холбоотойгоор хичээл сургалтын үйл ажиллагаа зогссонтой холбоотойгоор санхүүжилт буурсан байна. Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлого 306.8 сая төгрөгөөр өссөн нь үйл ажиллагааны нийт үр дүн өсөхөд нөлөөлсөн байна.Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 569.9 сая, орон нутгийн төсвөөс 39.3 сая, нийт 617.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан байна.

Тайлант хугацаанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолыг үндэслэн сумын төсөвт 3 удаа өөрчлөлт оруулж, төсвийг 14.7 сая төгрөгөөр өсгөж, 632.2 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд: Цалин хөлс нэмэгдэл урамшилын зардлыг 27.6 сая төгрөгөөр өсгөж, нормативт зардлыг 19.0 сая төгрөгөөр бууруулсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 632.2 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 589.7 сая төгрөгийг улсын төсвөөс 34.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 545.0 сая, орон нутгийн төсвөөс 34.2 сая, төсөвт байгууллагын өөрийн орлого 9.1 сая, нийт 588.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 588.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 588.4 сая төгрөг буюу 93.07 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшилын зардлыг 35.1 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 0.9 сая төгрөгөөр, нормативт зардлыг 5.2 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бичиг хэргийн зардалд 0.1 сая, Түрээсийн номын зардал 0.7 сая төгрөг, БШУС-ын 2021 оны А/280 дугаар тушаалаар “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн 4.3 сая, БШУС-ын 2021 оны А/279 дугаар тушаалаар ариутгалд зориулан Засгийн газрын нөөц сангаас 0.5 сая төгрөг, нийт 5.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5.6 сая төгрөг буюу 100 хувь зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал гараагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно.

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 93.07 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 632.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 588.4 сая төгрөгийг зарцуулж, 93.07 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:
  - Албан конторын тавилга, шагнал, албан томилот, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
2. Цар тахалтай хандив тусламжтай холбоотой: Ковид-19 цар тахалтай холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандив тусламжийг хүлээн аваагүй байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд тайлант онд 149 мэдээлэл байршуулахаас 137 мэдээлэл хугацаанд нь оруулж, 1 мэдээлэл огт оруулаагүй, 11 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.4, 6.5.6 дахь заалтуудтай нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

- Өмнөх оны аудитаар өгсөн цахим төлбөрийн баримтын гүйцэтгэлд хяналт тавьж, и-баримтыг шаардан авч, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах талаар зөрчлийг давтан гаргахгүй байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй буюу тайлант оны эцэст 4 аж ахуйн нэгжээс 1.6 сая төгрөгийн төлбөрийн баримтгүй ажил гүйлгээг гаргасан байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх, хариуцлага тооцуулах албан шаардлага өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт нь холбогдох шалгуурт тус тус бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж, зөрчил арилгах 4 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Өмнөх оны зөвлөмж, албан шаардлагыг тайлант онд бүрэн биелүүлэн ажиллаагүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1 алдааг залруулж, 4.0 сая зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй 3 алдаа, зөрчлийн дүн 4.0 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 13.3 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар зэрэгцүүлсэн мэдээлэл өмнөх тайлант хугацааны дүн нь өмнөх оны санхүүгийн тайлагналын аудитын дүнтэй дүйцэж буй байдлыг хянахад цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны гүйцэтгэлийг үнэн зөв мэдүүлж тайлагнаагүйг санхүүгийн тайланд залруулав.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 0.9 сая төгрөгийн 1 төрлийн 2 ширхэг үндсэн хөрөнгийг бараа материалын ангилалд бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн тодорхойлолт 13 дугаар зүйл Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах биет хөрөнгө: а.Бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үйлдвэрлэлт буюу нийлүүлэлтэд, бусдад түрээслэхээр эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж буй байгууллагын эзэмшиж байгаа; б.Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх.

#### Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цахим төлбөрийн баримтын системд 4 аж ахуйн нэгжээс 1.6 сая төгрөгийн төлбөрийн баримтгүй ажил гүйлгээг гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-д "Бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтуудтай нийцээгүй

**Өгсөн зөвлөмж:** Цахим төлбөрийн баримтын гүйцэтгэлд хяналт тавьж, и-баримтыг шаардан авч, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах талаар зөрчлийг давтан гаргахгүй байх

**Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тайлант онд шуудан, холбоо, интернетийн төлбөр /210403/ зардлын данснаас 0.25 сая төгрөгийн шатахууны үнэ, хоол хүнс /210502/ зардлын данснаас 0.75 сая төгрөгийн эмний үнэ, нормын хувцас, зөөлөн эдлэл /210503/ зардлын данснаас 0.5 сая төгрөгийн эмний зардлыг гаргасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Булган сумын ЕБС	4	4.0	1				1		3	4.0
Дүн		4	4.0	1				1		3	4.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Булган сумын ЕБС	1	-					1	-		
Дүн		1	-					1	-		
<b>Нийт дүн</b>		<b>5</b>	<b>4.0</b>					<b>2</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>4.0</b>